

Монголын шашны ландшафт дахь есүс христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүмийн төлөвшил ба онцлог

Жаргалын Алтайбаатар, доктор (Ph.D)

Удирдлагын академи, Улаанбаатар, Монгол Улс

altaibaatar@naog.gov.mn; <https://orcid.org/0000-0002-4541-0527>

Article history

Received : 2025-08-31

Accepted : 2025-11-30

Published : 2025-12-31

Түлхүүр үгс

шашны газарзүй, шашны ландшафт, шашны орон зай, шашин ба нийгэм, шашин шүтлэгийн төлөв байдал, шинэ шашны хөдөлгөөн, шинэ шашин, Есүс Христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүм, Мормончууд

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Монголын шашны ландшафт дахь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм (ЕХХҮГС)-ийн төлөвшил, онцлогийг авч үзэв. 1990-ээд оны эхэн үед Монголд нэвтэрч эхэлсэн ЕХХҮГС нь богино хугацаанд хурдацтай өргөжин тэлж, өнөөдөр Монголын шашны орчин үеийн төлөв байдлын чухал бүрэлдэхүүн хэсэг болжээ. Энэ судалгаа нь сүмийн түүхэн хөгжил, зохион байгуулалтын бүтэц, сүсэгтнүүдийн тоо, хүн ам зүйн шинж чанар, нийгмийн үйлчилгээ, хүмүүнлэгийн үйл ажиллагаа зэрэг олон талыг тоймлон авч үзсэн болно.

The development and characteristics of the church of jesus christ of latter-day saints in the religious landscape of mongolia

Altaibaatar Jargal, Ph.D

National Academy of Governance, Ulaanbaatar, Mongolia

altaibaatar@naog.gov.mn; <https://orcid.org/0000-0002-4541-0527>

Keywords

religious geography, religious landscape, religious space, religion and society, situation of religion, new religious movement, new religion, The Church of Jesus Christ of Latter-day Saints, Mormons

Abstract: This article examines the development and distinctive features of The Church of Jesus Christ of Latter-day Saints (LDS Church) within the religious landscape of Mongolia. Having entered Mongolia in the early 1990s, the LDS Church expanded rapidly within a relatively short period and has since become an important component of the country's contemporary religious environment. The study outlines multiple dimensions of the Church's presence in Mongolia, including its historical development, organizational structure, membership growth and demographic characteristics, as well as its social services and humanitarian activities.

© The Author(s), 2025



I. ОРШИЛ

“Шашны ландшафт” буюу “шашны орон зай” (religious landscape) хэмээх нэр томъёог сүүлийн үеийн шашин судлал, тэр дундаа шашны социологи, шашны антропологи, шашны газарзүй зэрэг олон салбар судалгаанд өргөн хэрэглэх болсон бөгөөд тухайн нийгэмд шашин ямар байр суурь эзэлж буйг олон хэмжээсээр тайлбарлахад чухал үүрэг гүйцэтгэж байна¹.

“Ландшафт” буюу “орон зай” гэх нэр томъёог эхэндээ газарзүй, соёл судлалын хүрээнд хэрэглэж, тухайн нийгмийн үнэт зүйл, соёлын илэрхийлэл газар нутагт хэрхэн шингэсэн байдлыг илтгэх агуулгаар, ихдээ л шашны газар зүйн судалгааны хүрээнд багтаан судалж байжээ (Cosgrove, 1984). Тухайлбал, XVI–XVII зууны өрнө дахинд Христийн шашны нөлөө газарзүйн шинжлэх ухааны салбарт нөлөөтэй байсныг илтгэж “сүмийн газарзүй” (ecclesiastical geography) болон “библийн газарзүй” (biblical geography)-н судалгаа давамгайлах болсон бөгөөд үүний ачаар орон зайн хувьд шашин шүтлэг хэрхэн түгэн тархаж, түүнийг номлогчид, түгээгчдийн үйл хэрэг ямар үр дүнд хүрч байсныг тогтоох судалгааны эхлэл тавигдаж байжээ².

Ялангуяа Макс Вебер (Weber, 1904-1905), Эмиль Дюркгейм (Durkheim, 1976), Рюдолф Отто (Otto, 1950), Мерч Элиаде (Eliade, 1959) нарын судалгаа шашин судлалыг мэдлэгийн олон салбарын уулзвар дээр хөгжихөд ихээхэн чухал нөлөө үзүүлсэн (Kong,

1990) бөгөөд улмаар шашны ландшафтын тухай судалгаа нь тухайн нийгмийн шашны олон янз байдал, түүний харьцаа, тархалт, институцийн тогтолцоог илэрхийлэх ойлголт болтлоо хөгжжээ.

Социологич П.Бергер, Т.Лукман нар “нийгэм” бол хүмүүсийн харилцан үйлдэл, бүтээн байгуулалтын үр шимээс бий болсон “бодит байдал”-ын тухайн үзэл баримтлалынхаа хүрээнд нийгэм дэх шашны институцийн оршихуйг тодорхойлсон (Peter L. Berger, Thomas Luckmann, 1967). Тэднийхээр шашны ландшафт нь зөвхөн тодорхой орон зай дахь сүм хийдийн тархалт төдий бус бөгөөд харин нийгмийн бодит байдалд шашны үзэл суртал, институци хэрхэн нэвчин шингэж буйг тайлбарлахад чиглэдэг байна.

Антропологич Клиффорд Гийрц шашныг зөвхөн итгэл үнэмшлийн цогц, эсвэл зөвхөн ёслол зан үйлийн багц төдийгөөр хязгаарлалгүй, харин утга учир, бэлгэдлийн цогц систем (Geertz, 1993) гэж үзсэн. “Шашин бол тэмдэгт, бэлгэдлийн систем бөгөөд тэр нь хүмүүсийн ертөнцийг үзэх үзэл ба амьдралдаа мөрдлөг болгодог хэм хэмжээг (ёс зүй) нэгтгэн, тэдний хувьд бодит байдлыг утга учиртай, үнэмшилтэй болгож өгдөг” (Geertz, 1966) ажээ. Өөрөөр хэлбэл “шашин бол соёлын систем” бөгөөд энэ системийн утга учир, бэлгэдэл, итгэл үнэмшил нь зөвхөн хүний оюун санаанд бус, ландшафтын бүтэц, орон зайн зохион байгуулалт дээр бодитой болж өгдөг.

¹ АНУ-ын PEW Research Center байгууллагын “The Global Religious Landscape: A Report on the Size and Distribution of the World’s Major Religious Groups as of 2010”, “Religious Landscape Study (RLS 2023–24)” зэргийг дурдаж болно. 2024 оноос МУИС-ийн Баруун бүсийн сургууль, ОХУ-ын Оросын биотехнологийн их сургуулийн судлаачид хамтран “Орос-Монголын хил орчмын шашны ландшафт: шашин шүтлэг, угсаатны өвөрмөц байдлыг бий болгож буй институци, сүлжээний

механизм, шашин ба аюулгүй байдал” сэдэвт олон улсын судалгааг эхлүүлжээ.

² “Сүмийн газарзүй” нь Христийн болон бусад шашнуудын дэлхий даяарх тархалтыг зураглаж, аль бус нутагт ямар шашин байсныг, мөн христийн номлогчдын үйл ажиллагаа хэрхэн урагшилсныг баримтжуулах зорилготой байв (Isaac, 1965, p. 10). Харин “библийн газарзүй” нь библид дурдагдсан газар, нэрсийг тогтоох, байршилыг тодорхойлох оролдлого хийж байжээ (Kong, 2008).

Шашны ландшафт бол Гийрцийн “соёлын систем”-ийн материаллаг илрэл гэж хэлж болно.

Ийнхүү шашны ландшафт хэмээх ухагдахуун зөвхөн тодорхой шашны тархалт, газар зүйн байршлыг заагаад зогсохгүй тухайн шашин нийгэм, соёлын бүтэц дотор хэрхэн байр сууриа эзэлж буйг, өөр шашин, үзэл сурталтай ямар харилцаа, зөрчил, зохицолд оршиж байгааг судлахад хэрэглэгдэх болжээ (Beyer, 2006); (Vasquez, 2011).

Өнөө үед шашны ландшафтыг шашны олон янз байдлын динамикийг тайлбарлахад ашиглаж байна (Cesari, 2013); (Beyer, 2006). Тухайлбал, PEW судалгааны байгууллага 2007 оноос эхлэн АНУ-ын шашны ландшафтын судалгааг 3 удаа хийсэн бөгөөд сүүлийнхийг нь 2023-2024 онд гүйцэтгэжээ.

Монголын нөхцөлд “шашны ландшафт” нь буддын шашны уламжлал, бөө мөргөлийн нөлөө, христийн шашны олон янзын урсгал, исламын шашны цөөнхийн оршин тогтнохуй, түүнчлэн

II. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгаанд дараах зарчим, арга зүйг баримтлав:

1. Үнэлэмжээс ангид байх. Үнэлэмжээс ангид байх зарчим нь шашин судлалын үндсэн арга зүйн шаардлагын нэг юм. Өөрөөр хэлбэл аливаа шашныг судлахдаа тухайн итгэл үнэмшлийн “үнэн зөв” эсэхийг хэмжих бус, харин түүний түүхэн үүсэл хөгжил, соёлын илэрхийлэл, нийгмийн байр суурь, эрх зүйн зохицуулалт зэрэг олон өнцгөөс шинжлэх шаардлагатай. Энэ өгүүлэлд ЕХХҮГС-ийн тухай судалгааг хийхдээ аливаа хувийн үнэлэмжид хөтлөгдөхөөс зайлсхийж, төвийг сахисан, тайлбарлах (descriptive-analytical) арга зүйг баримталсан болно.

орчин үеийн шинэ шашны хөдөлгөөнүүдийн идэвхжил зэрэг өргөн хүрээг хамарсан онцлогтой байна. Эдгээр нь зөвхөн шашны итгэл үнэмшил, зан үйл, шашны байгууллагын тоон тархалт, статистик үзүүлэлтээр хязгаарлагдахгүй бөгөөд шашныг зөвхөн түүхэн институцийн талаас нь төдийгүй улс төр, боловсрол, ёс суртахуун, нийгэм, соёлын харилцаанд нөлөөлж ирсэн шашны олон талт харилцааны онцлогийг гүнзгийрүүлэн судлах арга зүйн суурь болж байна.

Манай нийгэмд шинэ шашны хөдөлгөөнүүд өөрийн орон зай, байр суурийг эзлэн оршоор багагүй хугацаа өнгөрчээ. Энэхүү өгүүлэлд Есүс Христийн Хожмын үеийн гэгээнтнүүдийн сүм (цаашид ЕХХҮГС гэх) буюу нийтийн дунд Мормоны шашин хэмээн нэршсэн шашны хөдөлгөөний Монгол дахь төлөвшил, байр суурь, онцлогийг зохиогчийн 2019-2024 онд гүйцэтгэсэн судалгааны үр дүнд тулгуурлан харуулахыг зорилоо.

2. Үнэн зөв, бодитой байх. Үнэн зөв, бодитой байх зарчим нь судалгааны найдвартай байдлыг хангах суурь нөхцөл юм. Судалгааны өгөгдлийн итгэл төрүүлэхүйц чанарыг хангахын тулд тухайн шашны өөрийн эх сурвалж (албан ёсны түүх, тайлан, статистик мэдээлэл, ном хэвлэл) болон хөндлөнгийн эх сурвалж (төрийн болон олон улсын байгууллагын баримт, бие даасан судлаачдын бүтээл, хэвлэл мэдээллийн эх сурвалж)-ийг хослуулан ашиглав. Ингэснээр нэг талын мэдээллийн нөлөөнд хэт автах, хөтлөгдөх эрсдэлээс сэргийлэхийн зэрэгцээ тухайн үзэгдлийг илүү бодитой, олон өнцгөөс харуулах боломж бүрдэнэ гэж үзсэн болно.

- Судалгаанд дараах эх сурвалжийг ашиглав:
- Анхдагч эх сурвалж:
 - 2023, 2024 онуудад Монгол Улс дахь ЕХХҮГС, АНУ-ын Солтлэйк дэх ЕХХҮГС-ийн Монгол чуулган, Халамжийн төв, Бишопын дэлгүүр, Брингим Янгийн их сургууль, Гэр бүлийн түүхийн номын сангийн үйл ажиллагаанд хийсэн ярилцлагын судалгааны тэмдэглэл.
 - Монгол Улсад ажиллаж байсан ЕХХҮГС-ийн Номлолын ерөнхийлөгч нар, монгол чуулганы тэргүүн, гишүүд зэрэг 20 хүнтэй хийсэн ярилцлагын судалгааны үр дүн.
 - Монгол Улсын Дархан-Уул, Сэлэнгэ аймгууд дахь сүмийн бишоп, дүүргийн ерөнхийлөгч, хүмүүнлэгийн төсөл хэрэгжүүлсэн төрийн байгууллагын ажилтнууд, тухайн байгууллагаар үйлчлүүлэгч иргэдтэй хийсэн ярилцлагын судалгааны тэмдэглэл.
 - Хоёрдогч эх сурвалж:
 - Олон улсын болон дотоодын судлаачдын нийтлэл, ном, өгүүлэл, ялангуяа шашны ландшафт, шинэ шашны хөдөлгөөн, Монгол Улс дахь шашны орчин үеийн төлөв байдалд хамаарах бүтээлүүд, судалгааны тайлан, өгөгдөл.
 - Монгол дахь ЕХХҮГС-ийн тухай албан ёсны баримт бичиг, статистик мэдээ, сүмийн цахим хуудас болон тэдгээрийн нийтлэл, хэвлэгдсэн материал.
 - 2024 оны 3-р сард ЕХХҮГС-ийн АНУ дахь Сүмийн түүхийн номын сан, архиваас цуглуулсан ажлын тайлан, намтар, ярилцлага, аман түүхийн тэмдэглэл, видео бичлэг, фото зураг, микрофильм зэрэг 7 төрлийн 70 гаруй баримт бичиг, нийт 1600 орчим хуудас материал зэрэг болно.
 - Судалгааны арга зүйг олон улсын жишигт дөхүүлэх зорилгоор “Pew Research Center”-ийн эрхлэн явуулсан U.S. Religious Landscape Survey (2024) зэрэг өргөн цар хүрээтэй судалгааны арга зүйд түшиглэсэн. Уг судалгаа нь АНУ дахь шашны олон янз байдлыг социологийн болон статистикийн аргаар бүртгэн шинжилсэн бөгөөд том хэмжээний түүвэр, асуулга, тоон болон чанарын мэдээллийг хослуулсан арга зүйн загварыг хэрэглэдэг. Энэ нь шашны ландшафтыг зөвхөн тоон талаас нь бус, институцийн байр суурь, шашны дадал заншил, итгэл үнэмшлийн түвшин зэрэг олон хэмжээсээр тайлбарлах боломжийг олгодог (Pew Research Center, 2024). Ийм арга зүйн туршлагыг энэхүү судалгаанд лавлагаа болгон авч хэрэглэв.
3. Судалгаанд дараах аргуудыг хослуулан хэрэглэв:
- Түүхэн-архивын арга. АНУ дахь Сүмийн түүхийн номын сан, Монгол дахь ЕХХҮГС-ийн албан архив болон албан ёсны хэвлэлүүдэд тулгуурлан сүмийн түүхийг баримт нотолгоонд үндэслэн шинжлэв.
 - Ярилцлагын арга. Монгол дахь ЕХХҮГС-ийн удирдагчид, гишүүд, хүмүүнлэгийн төсөл хэрэгжүүлэгчид болон хамтрагч байгууллагын ажилтнуудтай гүнзгийрүүлсэн ярилцлага хийж, тэдний шашны дадал заншил, байгууллагын бүтэц, нийгмийн оролцооны талаарх ойлголт, туршлагыг судалсан.
 - Ажиглалтын арга (талбарын судалгаа). Монгол чуулганууд болон хүмүүнлэгийн төвийн үйл ажиллагаанд оролцож, сүмийн ёслол, хурал, сургалт, хүмүүнлэгийн арга хэмжээг судалгааны тэмдэглэлээр баримтжуулсан.
 - Баримт бичгийн шинжилгээ. Сүмийн албан ёсны тайлан, статистик мэдээлэл, бодлогын баримт бичиг, мөн төр, шинжлэх ухааны болон олон улсын байгууллагын тоо баримт,

судалгааны тайлан зэрэг барим бичгүүдийг харьцуулан шинжилж, бодит мэдээллийн найдвартай байдлыг хангасан.

- Харьцуулалт. Монгол дахь ЕХХҮГС-ийн төлөвшлийг АНУ болон бусад

III. ҮНДСЭН ХЭСЭГ

Монголын шашны ландшафт дахь ЕХХҮГС-ийн төлөвшил, байр суурь, онцлогийг нэгд, Есүс Христийн Хожмын үеийн гэгээнтнүүдийн сүмийн итгэл үнэмшил, зан үйл; хоёрт, Монгол Улс дахь ЕХХҮГС-ийн үүсэл, төлөвшил; гуравт, сүсэгтнүүд; дөрөвт, нийгэм, хүмүүнлэгийн үйл ажиллагаа гэсэн үндсэн дөрвөн хэсэгт тоймлон авч үзлээ.

Есүс Христийн Хожмын үеийн гэгээнтнүүдийн сүмийн итгэл үнэмшил, зан үйл

Есүс Христийн Хожмын үеийн гэгээнтнүүдийн сүмийн (ЕХХҮГС, Мормоны шашин) албан ёсны түүх сүмийн үүсгэн байгуулагч Иосеф Смит (Joseph Smith, 1805–1844) болон өөр бусад 6 хүний хамтаар анхны цуглаанаа эхлүүлсэн 1830 оны 4-р сарын 6-ны өдрөөс эхлэлтэй (Bushman, 2005). 200 шахам жилийн хугацаанд анхны 7 гишүүнээс дэлхий даяар 17.5 сая гишүүнтэй болтол өргөжсөн⁴ бөгөөд АНУ-д хамгийн эрчимтэй өссөн, нөлөө бүхий шинэ шашны хөдөлгөөн хэмээн дүгнэсэн байдаг (PRRI, 2012). Өнөөдөр энэ шашны сүсэгтнүүд 36000 орчим сүмийн зохион байгуулалтын нэгжид харьяалагдан шашны үйл ажиллагаанд оролцож (2024 Statistical Report of The Church of Jesus Christ of Latter-day Saints, 2025), жил бүр 5.5-6.5 тэрбум орчим америк долларын хандивыг сүмийн шашны болон

орны нөхцөл байдалтай харьцуулан тайлбарлаж, шашны ландшафт дахь байр суурийг олон улсын түвшинд ойлгохыг зорив.

шашны бус (боловсрол, хүмүүнлэгийн гэх мэт) үйл ажиллагаанд зориулан өргөдөг тухай мэдээлэл бий (Semerad, 2025).

ЕХХҮГС нь Христийн шашинд үндэслэсэн боловч Есүс Христийн сургаалыг орчин үеийн нөхцөлд сэргээсэн гэсэн тайлбарыг өөрсдөө өгдөг. Сүмийн итгэгчид Есүс Христ өөрөө энэхүү сүмийг үндэслэж, Иосеф Смит дахин сэргээсэн гэж үздэг байна (Givens, 2003). Шашин судлалын үүднээс авч үзэхэд ч энэ шашны номлол сургаал, үзэл санаа, зан үйл нь Христийн шашнаас ялгаатай, өвөрмөц онцлогийг агуулдаг. Тухайлбал,

- Зөвхөн “Ариун Библи” бус, “Мормоны ном”, “Сургаал ба Гэрээ”, “Агуу үнэт сувд” зэрэг “Сүмийн жишиг бүтээл” (Standart Works) хэмээн нэрлэгдсэн албан ёсны бүтээлүүдийг чухалчилан дээдэлдэг;
- “Эцэг Бурхан, Есүс Христ, Ариун Сүнс бол гурван тусдаа, бие даасан оршихуй” гэхчилэн Бурханы оршихуй, нөгөө ертөнцийн амьдрал, хойд насны тухай Христийн шашны түгээмэл, уламжлалт үзлээс ялгаатай үзэл номлодог;
- Христийн шашинтай адил баптисм хүртэж шашинд орохоос гадна Христийн шашны уламжлалаас эрс ялгаатай аврал, мөнхийн амьдралд хүрэхийн тулд зайлшгүй гүйцэтгэх ёстой зан үйлүүдийг мөрддөг (тухайлбал, хишиг хүртэх, лацдан

⁴ ИХХҮГС-ийн албан ёсны статистикт 2024 оны байдлаар дэлхий дахинаа сүмийн нийт сүсэгтэн 17 сая 509 мянгад хүрсэнийг мэдээлжээ.

- холбогдох, нас барагсдын төлөөх баптисм гэх мэт);
- Гэр бүлийн гишүүд ариун сүмд холболт хийж лацлагдсанаар нас барсны дараа ч мөнхөд хамт байна гэж үздэг;
 - Сүмийн үйл хэргийг тусгайлан гүйцэтгэх шашны зүтгэлтнүүдийн оронд сүсэгтнүүд ээлжлэн үүрэг хүлээн (дуудлага гэж нэрлэдэг) сүмд үйлчилдэг, үүний дотор хосоороо гүйцэтгэх номлогчийн үүрэг ч багтдаг.
 - Архидалт, мансууруулах бодис, никотин, кофеин зэрэг донтолт үүсгэдэг бодисуудыг хэрэглэхээс татгалзах дадлыг бий болгохыг чухалчилдаг.
 - Сүсэгтнүүдийн орлогын 10-ны 1 хэмээх хандивт суурилан сүмийн үйл ажиллагаа, хүмүүнлэг, боловсрол, эрүүл мэндийн зэрэг олон хөтөлбөрүүдийг санхүүжүүлдэг гэх мэт.

Эдгээрээс зарим нэг нь Христийн шашны уламжлалт үзэл баримтлалтай нийцдэггүй буюу ялгаатай байдаг тул зарим судлаачид, шашны зүтгэлтнүүдийн зүгээс үндсэн номлолоос гажсан “гаж урсгал” гэж үзэх нь бий⁵.

Дээр дурдсанчлан сүмийн үйл ажиллагаа нь лам, хувраг зэрэг шашны зүтгэлтнүүд бус, энгийн сүсэгтнүүдийн тогтолцоо, зохион байгуулалтад суурилдаг байна. ЕХХҮГС нь дэлхий даяар адил бүтэцтэйгээр зохион байгуулагддаг ба Удирдах газар, Орон нутгийн цуглаан, Туслах байгууллагууд гэсэн үндсэн бүтэцтэй. Тухайлбал, 15 төлөөлөгчөөс (апостол) бүрдэх Дээд удирдлага (энэ 15 төлөөлөгчөөс Сүмийн ерөнхийлөгч, 2 зөвлөхийг сонгож Тэргүүн Зөвлөлийг бүрдүүлэх бөгөөд

харин бусад арван хоёр төлөөлөгч сүмийн дэд удирдлага болох Арван хоёр төлөөлөгчийн чуулгыг бүрдүүлдэг), Арванхоёр төлөөлөгчид туслах үүрэгтэй “Дал (70)” гэж нэрлэдэг бүтэц сүмийн удирдлагыг хэрэгжүүлдэг.

Харин сүмийн сүсэгтэн буюу гишүүдийг газарзүйн зарчмаар харьяалуулж зохион байгуулдаг. Орон нутгийн цуглаан буюу “салбар”-ыг Бишоп удирдах бөгөөд түүний удирдах харьяа нутгийг “тойрог” гэнэ. Харин хэд хэдэн тойргийг нэгтгэн “гадас” гэж нэрлэдэг. “Гадас”-ын ерөнхийлөгч болон бишопууд тухайн нутаг дэвсгэр дэх сүсэгтнүүдтэй нүүр тулан харилцаж сүсэг бишрэлийн болон бусад ахуйн шинжтэй (боловсрол, туслалцаа дэмжлэг гэх мэт) асуудлуудыг гардан шийдвэрлэдэг байна. Харин сүсэгтнүүд тухайн газар нутаг дахь цуглааны хэвийн үйл ажиллагааг хангахад тодорхой хугацаагаар үүрэг хүлээж ажилладаг.

Үүнээс гадна тодорхой нутаг дэвсгэрт үйлчилж буй бүх номлогчид (missionaries) болон тухайн ажлыг удирдан зохион байгуулах нэгж болох “Номлол” (Mission) гэх нэгж бас бий.

Тухайн газар нутаг дахь цуглааны үйл ажиллагааг хэвийн явуулахад туслах үүрэгтэй Халамжийн Нийгэмлэг, Ням гараг, Залуу эрэгтэйчүүд, Залуу эмэгтэйчүүд, Хүүхдийн хэсэг нэртэй орон нутгийн туслах бүлгүүдийг мөн зохион байгуулдаг. Эдгээр нь тухайн нэр оноосон чиг үүргийн дагуу боловсрол олгох, хамтран асуудлаа хэлэлцэх, халамжийн үйлчилгээ үзүүлэх зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг ажээ.

Ингэж ЕХХҮГС нь шашны уламжлалт шатлан захирах санваартны тогтолцооны оронд сүсэгтнүүдийнхээ хүчин чармайлт, идэвхэд суурилсан

⁵ Шашны үндсэн номлол, сургаалыг уламжлалт бус байдлаар тайлбарлаж, шинэ үзэл санаа, сүсэг бишрэлийг бий болгох үзэгдлийг “культ”, “cult”, “гаж буруу” урсгал гэж үзэх нь бий. Гэвч орчин

үеийн шашин судлалд энэхүү хандлагыг субъектив шинжтэй гэж үзэх болсон тул “шинэ шашны хөдөлгөөн” буюу “new religious movement” гэх нэр томъёог түлхүү хэрэглэж байна.

тогтолцоог ашигладаг нь уламжлалт бус байдлаар өөрийгөө илэрхийлдэг шинэ шашны хөдөлгөөний нэгэн өвөрмөц шинж юм. Сүмийн дотоод зохион байгуулалт, удирдлагын бүтэц, шашны үйл ажиллагаанд зөвхөн сонгогдсон цөөнхийн бус нийт гишүүдийн оролцоог чухалчилж, шашин шүтлэгийг хувь хүний идэвх, үүрэг хариуцлага, нийгмийн оролцоотой нягт холбосон нь түүний “Америк маягийн” гэх онцлог шинжийг тодотгож байна.

ЕХХҮГС-ийн зан үйлийн тогтолцооны төвд "Ариун сүм" (temple) гэх ойлголт чухал байр суурьтай байх бөгөөд энэ нь тэдний шашны хамгийн дээд ариун газрыг илэрхийлдэг. Ариун сүм нь өдөр тутмын үйл ажиллагаа, мөргөл, ариун ёслолын цуглаан зэрэг шашны үйл ажиллагаа явагддаг, бүх хүнд нээлттэй байдаг "сүмийн байр" (meetinghouse, chapel, church)-аас онцгой ялгаатай юм. Ариун сүм бол зөвхөн тодорхой бэлтгэлтэй, зөвшөөрөлтэй сүсэгтнүүд л нэвтрэх эрхтэй газар юм. Энд хийгдэх зан үйлүүд нь шашны уламжлалт өдөр тутмын мөргөл бус, харин авралын чухал, онцгой ёслолууд байдаг. Тухайлбал, хишиг хүртэх, лацдан холбогдох, нас барагсдын баптисм зэрэг зан үйлүүдийг л энд гүйцэтгэнэ.

2025 оны байдлаар дэлхий даяар нийт 202 Ариун сүм баригдан ажиллаж байгаа бөгөөд харин 165 сүм барихаар зарлаад байна. “Ариун сүмийг зарлана” гэдэг нь тухайн хот, бүс нутагт шинэ ариун сүм барих шийдвэрийг сүмийн ерөнхийлөгч албан ёсоор мэдэгдэж байна гэсэн үг юм. Энэ нь шууд барилгын ажил эхлэхийг хэлдэггүй, харин ЕХХҮГС-ийн ирээдүйн төлөвлөгөөнд тухайн ариун сүмийг багтааж буйг илэрхийлдэг. Монгол Улсад одоогоор ариун сүм байхгүй боловч 2023 оны 10-р сард Ариун сүм барихыг зарласан. Ариун сүмийн ёслолын зан үйлд оролцохын тулд хамгийн ойр орших Хонгконгийн ариун сүмд очих

шаардлагатай болдог монгол сүсэгтнүүдийн хувьд энэ мэдээ бол маш чухал зүйл ажээ. Учир нь хойд насны амьдралын бүхий л чухал бэлтгэлийг хийх буюу “авралд багтах” боломж газарзүйн хувьд улам бүр ойртож байна гэсэн үг юм.

Монгол Улс дахь ЕХХҮГС-ийн үүсэл, төлөвшил

Монгол Улс ардчилсан өөрчлөлтийн замд орж, 1992 оны шинэ Үндсэн хуулиар иргэдийн шашин шүтэх, эс шүтэх эрхийг баталгаажуулснаар шашны байгууллагуудад шинэ боломж нээгдэв. Энэ түүхэн нөхцөл нь шашны янз бүрийн урсгал чиглэлүүд, тэдний дотор Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм (цаашид ЕХХҮГС гэх)-ийн Монгол Улсад нэвтрэх нөхцөл бүрджээ.

ЕХХҮГС-ийн Монгол дахь эхлэл нь хүмүүнлэгийн ажлуудаас эхтэй. 1984 онд Сүмийн удирдагчдын нэг Монте Ж. Броу Монголд аялсан нь анхны харилцаа тогтох эхлэл болсон байна. 1991 оны гуравдугаар сард БНМАУ-аас АНУ-д суух анхны элчин сайд Гэндэнгийн Нямдоо Брингхам Янгийн их сургуульд лекц уншиж, сүмийн Тэргүүн зөвлөлтэй уулзалт хийсэн нь Монгол Улсын төр засаг ЕХХҮГС-тэй албан ёсоор холбогдсон анхны тохиолдол гэж хэлж болно.

1992 онд Монте Ж. Броу Азийн бүсийн удирдлагын хувиар дахин ирж, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх нөхцөл боломжийг судалжээ. Энэ үеэр Монголын талтай хийсэн уулзалт, хэлэлцээрүүдийн үр дүнд Улаанбаатарт анхны ахмад гэр бүлүүд англи хэл заах, боловсролын салбарт дэмжлэг үзүүлэх хэлбэрээр ажиллаж эхэлсэн байна. Боловсролын салбар дахь энэ дэмжлэгийн тухай Монте Ж. Броу, “монголчуудад тус дэм болохоос гадна, номлолын үйл ажиллагаа эхлүүлэх үүд ч байж болох” тухай өгүүлж байжээ. 1992 оны 9 сард ахмад номлогч хос болох

Кеннет ба Донна Бийсли нарын гэрт Монгол дахь ЕХХҮГС-ийн анхны ариун ёслолын цуглаан⁶ зохион байгуулагдсан ажээ (Po Nien (Felipe) Chou, Petra Chou, 2022).

1993 оны 4-р сарын 15-нд анхны хоёр монгол иргэн болох Ламжавын Пүрэвсүрэн, Цэндхүүгийн Бат-Өлзий нар баптисм хүртсэн нь ЕХХҮГС-ийн Монгол дахь үйл ажиллагааны албан ёсны эхлэл болжээ (Mongolia Dedicated for preaching of the Gospel, 1993).

1994 онд ЕХХҮГС албан ёсоор шашны байгууллага гэж бүртгэгдсэнээр сүмийн гадаад номлогчид Монгол Улсад идэвхитэй ажиллах болсон байна. 1990-ээд оны сүүл гэхэд Улаанбаатар хотод хэд хэдэн салбар байгуулагдаж, Дархан, Эрдэнэт томоохон хотуудад үйл ажиллагаа нь өргөжин тэлжээ. 1995 онд Улаанбаатар Монгол номлол байгуулагдаж, анхны номлолын ерөнхийлөгчөөр Ричард Күүк томилогдсоноор шашны сургаал номлол түгээх ажлыг зохион байгуулах тогтолцоо бүрэлдсэн байна. Улаанбаатар Монгол номлол үндэсний хэмжээнд гадаадаас бэлтгэгдэж ирсэн номлогчдын үйл ажиллагааг зохион байгуулахаас гадна монгол номлогчдыг бэлтгэх, номлолд үйлчлэх ажлыг зохион байгуулалт, удирдлагаар хангаж иржээ.

Ийнхүү 1990-ээд он бол ЕХХҮГС-ийн хувьд Монгол Улсад үндэс сууриа тавьсан он жилүүд байжээ. Энэ үед сүмийн номлолын үйл ажиллагаа шууд сурталчилгаанаас илүүтэйгээр хүмүүнлэгийн төсөл, боловсролын дэмжлэг, англи хэлний сургалт зэрэг “зөөлөн хүчний” арга барилд тулгуурлаж

өрнөсөн нь тухайн үед Монголд шинээр нэвтэрч байсан шашны бусад урсгалуудаас ялгарах онцлогтой байв. Сүмийн ахмад гишүүд болон сайн дурынхан англи хэлний багш, их дээд сургуулийн зөвлөхөөр ажиллаж, боловсролын чанарыг дээшлүүлэхэд оролцож байсан нь нийгмийн тодорхой нэг хэсэгт танигдан, тэдний зүгээс итгэл хүлээж, улмаар сүсэгтний эгнээгээ өргөтгөх нөхцөлийг бүрдүүлсэн гэж хэлж болно.

Монгол Улсад ЕХХҮГС харьцангуй богино хугацаанд эрчимтэй түгсэн гэж судлаачид үздэг. 2001 онд Мормоны ном монгол хэлээр хэвлэгдэн хэрэглээнд нэвтэрсэн нь Монгол сүсэгтнүүдийн хувьд сүсэг бишрэлийн чухал эх сурвалж болжээ. Улмаар монгол залуус өөрсдөө номлогчоор үйлчлэх⁷ болсон. Монголд анх нэвтэрсэн 1990-ээд оны эхэн үетэй харьцуулвал 20 жилийн хугацаанд буюу 2010 он гэхэд 10000 орчим сүсэгтэнтэй болсон нь харьцангуй хурдан өсөлт юм. Энэ тухай дараагийн хэсэгт тодорхой авч үзнэ.

2009 онд Монгол дахь анхны “гадас” байгуулагдаж, анхны ерөнхийлөгч нь монгол хүн болсон нь ЕХХҮГС институцийн хувьд төлөвшиж эхэлсэний илрэл байлаа (LDS Church News, 2009). Монголд гадас байгуулагдсанаар сүмийн бүтэц илүү өндөр түвшинд шилжиж, гишүүдийн оролцоо, удирдлагын үүрэг, номлолын үйл ажиллагаа эрчимжихэд нөлөөлжээ.

Өнөөдөр Монголд ЕХХҮГС-ийн зохион байгуулалтын бүтэц дараах байдалтай байна.

⁶ “Ариун ёслолын цуглаан” (Sacrament Meeting) нь ЕХХҮГС-ийн долоо хоног бүрийн хамгийн гол мөргөлийн хурал юм. Христийн шашны бусад уламжлалд ч байдаг талх, дарс хүртдэг энэ

ёслолд дарсыг орлуулан ашигладагаараа бусад урсгалаас ялгардаг.

⁷ Цалин хөлс бүхий ажиллагчаас ялгаатай тул христийн шашинд түгээмэл хэрэглэдэг “үйлчлэх, үйлчлэл” хэмээх нэр томъёог ашиглав.

№	Байгууллагын төрөл	Нэгжийн тоо 2024–2025
1	Гадас (Stake)	2
2	Дүүрэг (District)	1
3	Тойрог (Wards)	12
4	Салбар нэгж (Branches)	12
5	Номлол (Mission)	1
6	Гэр бүлийн түүхийн төв (FHC)	10

Хүснэгт 3. ЕХХҮГС-ийн нэгжийн тоо (The Church in Mongolia, 2025)

Өнөөдрийн байдлаар Монгол Улс дахь ЕХХҮГС-ийн зохион байгуулалтын бүтэц нь институцийн хувьд төлөвшиж, олон улс дахь нийтлэг загварт дөхөж буйг харуулж байна. 2025 оны байдлаар сүм хоёр гадастай, нэг дүүрэгтэй болж өргөжсөн нь байгууллагын шатлалын хувьд нилээд өндөр түвшинд хүрчээ. Нийтдээ 12 тойрог, 12 салбар нэгж үйл ажиллагаа явуулж, Улаанбаатар Монгол номлолын дор нэгдэн ажиллаж байна.


Ийнхүү Монгол дахь ЕХХҮГС нь тоон үзүүлэлтээр төдийгүй бүтэц,

зохион байгуулалтын хувьд Монголын шашны ландшафтад өөрийн гэсэн орон зай, байр суурийг нэгэнт олсон байна.

Сүсэгтнүүд

Монгол дахь ЕХХҮГС-ийн сүсэгтний тоо анх 1990-ээд оны дунд үеэс эрчимтэй өсч эхэлсэн тухай өмнө дурдсан билээ. 2009 онд Монголд анхны гадас байгуулагдах үед сүмд албан ёсоор бүртгэгдсэн сүсэгтний тоо 7000 орчимд хүрсэн бөгөөд 2010 онд 9896 дахь сүсэгтэн баптисм хүртжээ (Martinich, 2013).

Зураг 3. ЕХХҮГС-ийн сүсэгтнүүдийн өсөлт



Сүм анх байгуулагдах үед сүсэгтний тоо 1993 онд 100 байсан бол 1995 онд 400, 1997 онд 1100, 1999 онд 1850, 2001 онд 3521, 2003 онд 5455 болсон байна. 1993 оноос 2003 он хүртэл жилийн гишүүдийн өсөлтийн дундаж хувь 20%-аас давжээ (Martinich, 2013).

Сүсэгтний тоо ийнхүү огцом нэмэгдсэн явдал нь тухайн үед ЕХХҮГС-ийн удирдлагуудын анхаарлыг ч татаж байжээ. Тухайлбал, Арван хоёр

төлөөлөгчийн нэг Жефри Холланд 2011 онд Монгол Улсад хийсэн айлчлалынхаа үеэр Монгол дахь сүмийн хөгжил нь бусад улс орны адил хэдэн арван жил шаардаагүй, харин маш богино хугацаанд (ердөө 20 жил хүрэхгүй хугацаанд) институцийн бүтэц, гишүүдийн тоо, удирдлагын тогтолцоотой болсон нь “нэг өдөрт төрсөн мэт” гэж зүйрлэмээр хурдацтай хөгжсөн гэсэн санааг илэрхийлж байжээ

(Apostles Visit Church Members in India, Hong Kong and Mongolia, 2011).

Сүсэгтний тоо эрчимтэй өсөх болсон шалтгааныг судлаачид дараах байдлаар тайлбарлаж байна. Үүнд:

1. Хүн амын гуравны хоёр гаруй хувийг залуу үе эзэлдэг буюу шинэ содон зүйлийг хүлээн авах сонирхол өндөр;

2. Нийтийн бичиг үсэг тайлагдалт өндөр, бараг 100% буюу шашны сургаал номлол, эх сурвалжийг ашиглах боломжтой;

3. Ард иргэдийн 50% орчим хувь нь хот суурин газар, ялангуяа нийслэл Улаанбаатар хотод амьдран суудаг буюу сүм, мөргөлийн газарт ойрхон зэрэг байдал нөлөөлсөн байж болох талтай ажээ (C.Gessel, 2015).

Түүнчлэн 70 шахам жилийн дараа шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөг шинэ Үндсэн хуулиар баталгаажуулсан нь шинэ тутам

нэвтэрсэн шашны янз бүрийн урсгалд нээлттэй, сонирхон хандах хандлага бий болсон явдал ч нөлөөлсөн байх магадлалтай. Энэ нь зөвхөн ЕХХҮГС төдийгүй сэргэж байсан уламжлалт Буддын шашин, Ислам шашин, Бөө мөргөл, түүнчлэн Христийн шашны олон урсгал чиглэлүүдэд ч ийм ижил боломж, нөхцөл бүрдсэн юм.

Харин 2004 оноос сүсэгтний тоон өсөлт огцом саарч, жилийн өсөлт хурдацтай буурч, 2004 онд 16%, 2005–2010 онд 6–9% болжээ (Martinich, 2013). Үүний шалтгаан нь идэвх багатай гишүүдийг идэвхжүүлэх, гишүүдийг бэлтгэхэд сүмийн үйл ажиллагаа чиглэсэнтэй холбон тайлбарлаж байв. Ингэснээр 2006 онд сүмийн гишүүдийн тоо 7,306 болж, 2010 онд 9,896 хүрсэн байна.

Нөгөө талаар энэ үед Монгол Улс дахь бусад шашин шүтлэгт ч тодорхой өөрчлөлт ажиглагдсан байдаг.

	Бурханы шашинтан	Христийн шашинтан	Исламын шашинтан	Бөөгийн шашинтан	Шашны бусад урсгал, чиглэлүүд
2003	66.8	7.9	2.5	1	0.1
2010	53.0↓	2.1↓	3.0↑	2.9↑	0.4↑

Хүснэгт 4. Монголчуудын шашин шүтлэгийн өөрчлөлт, нийт хүн амд болон судалгаанд оролцогчдын тоонд харьцуулснаар (Ж.Алтайбаатар, 2012)

Тайлбар: 2003 онд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны захиалгаар гүйцэтгэсэн “XXI зууны эхний Монгол дахь шашин шүтлэг ба үндэсний аюулгүй байдал”, Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүн мэдээ, үр дүнд үндэслэн харьцуулав.

Хүснэгтээс үзэхэд нийт хүн амын дунд эзлэх Бурханы болоод Христийн шашинтны тоо хэмжээ илт буурсан нь харагдаж байгаа бөгөөд энэ нь нийгэм, соёлын олон хүчин зүйлтэй холбоотой байж болох юм. Тухайлбал, аливаа шашны ухуулга, сурталчилгаар шашны урсгал чиглэлд итгэж сүсэглэх, сүсэгтэн болох явдал буурсан; шашныг сүсэг бишрэл, итгэл үнэмшил гэхээсээ илүүтэйгээр соёл гэх илүү өргөн хүрээнд авч үзэх явдал бий болсон; шашны аливаа сургаал номлолд нухацтай

хандаж, таньж мэдэх, туршиж үзэхийг эрмэлзэх болсон гэх мэт.

2010-аад оноос гишүүдийн өсөлт удааширсан бөгөөд жилийн өсөлтийн хувь 1.6%-аас 3.7%-ийн хооронд хэлбэлзэж байжээ. 2013 онд сүмийн гишүүдийн нийт тоо 10763, 2016 онд 11436, 2019 онд 12261 болсон байна. 2019 онд сүмийн гишүүдийн өсөлт 3.1% хүрсэн нь 2012 оноос хойших хамгийн өндөр өсөлтийн түвшин байв (Martinich, 2013). Харин 2025 оны байдлаар Монгол Улсад 12624 гишүүн бүртгэлтэй байгаа

тухай тоон мэдээ сүмийн албан ёсны цахим хуудаст тэмдэглэгджээ (The Church in Mongolia, 2025).

Монгол Улсад олон зууны туршид Бурханы шашин болон Бөө мөргөл уламжлалт шашны үүргийг гүйцэтгэж ирсэн. 2020 оны Хүн ам, орон сууцны тооллогын дагуу Монголын 15 ба түүнээс дээш насны иргэдийн 59.4

хувь нь шашин шүтдэг бөгөөд шашин шүтдэг хүн амын 87.1% нь Буддын шашин, 2.2% нь Христийн шашин, 5.4% нь Ислам, 4.2% нь Бөө мөргөл, 1.1% нь бусад шашин (шинэ шашны хөдөлгөөнүүд, үүний дотор ЕХХҮГС багтана)-д хамаарагддаг байна (ҮСХ, 2020).

№	Шашин	Шашин шүтэгчдийн доторх хувь (%)	15+ хүн амд эзлэх хувь (%)	Тайлбар
1	Бурханы шашин	87.1	51.8	-
2	Христийн шашин	2.2	1.3	Үүнд католик, протестант, ортодокс урсгалууд багтсан
3	Ислам шашин	5.4	3.2	Ихэвчлэн казах үндэстнүүд голлосон.
4	Бөө мөргөл	4.2	2.5	Уламжлалт зан үйл давамгайл.
5	Бусад	1.1	0.65	Үүнд дээрх шашнуудад багтаагүй шинэ хөдөлгөөнүүд орно (ЕХХҮГС-ийн тоо багтсан).
+	Үүнээс ЕХХҮГС (12,200 гишүүн)	~0.62*	0.37	Тухайн үеийн сүмд бүртгэлтэй сүсэгтний нийт тоонд үндэслэн харьцуулан тооцоолсон.

Хүснэгт 5. Монгол Улсын шашны ландшафтын бүтэц (2020 он, 15+ насны хүн амын тооллогоор)

ЕХХҮГС-ийн сүсэгтнүүд шашин шүтэгчдийн 0.62 хувийг, 15-аас дээш насны хүн амын 0.37 хувийг эзэлж байна. Нийт хүн амын дотор эзлэх хувь, өсөлтийн хурдыг аваад үзвэл бүс нутгийн бусад улсуудтай харьцуулвал харьцангуй өндөр үзүүлэлт ажээ (Martinich, 2013).

Сүсэгтний тоогоор ч Монгол Улсад бүртгэлтэй шинэ шашны 50 гаруй хөдөлгөөний дотор хамгийн олон сүсэгтэнтэй шашны тоонд багтаж байна (С.Цэдэндамба, С.Янжинсүрэн, Ж.Алтайбаатар, Б.Мөнхцацралт, С.Дэмбэрэл, О.Бумдарь, 2020).

Одоогоор бидэнд сүсэгтнүүдийн хүн ам зүйн нарийн тодорхой мэдээлэл байхгүй байна. Анх Монгол Улсад нэвтэрч байх үеийн сүсэгтнүүдийн талаарх мэдээллээс үзэхэд насны хувьд гишүүдийн дийлэнх нь 18–35 насны залуус байсан бөгөөд энэ нь тухайн цаг үе, нөхцөл байдлын онцлог буюу сүмийн

эхэн үеийн өсөлтийн онцлогтой холбоотой. Сүмийн түүхийн архивын баримтуудад дурдсанаар, монгол сүсэгтнүүдийн олонх нь оюутан, залуу гэр бүлүүд байжээ. Түүгээр ч үл барам сүсэгтний тоо хурдацтай өсч байсны улмаас 250-аас дээш хүнтэй цуглаан хийх байр олж түрээслэх явдал нилээд бэрхшээл учруулдаг байжээ (Po Nien (Felipe) Chou, Petra Chou, 2022). Гишүүдийн хүйсийн харьцаанд эмэгтэйчүүд давамгайлдаг бөгөөд энэ нь Азийн бусад улс дахь сүмийн нөхцөл байдалтай төстэй байв. Ер нь аль ч шашны сүсэгтнүүдийн дотор эмэгтэйчүүд давамгайл байдаг нь манай үндэсний хэмжээний статистик мэдээллээс ч харагддаг.

Монгол Улс дахь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм (ЕХХҮГС) нь бусад олон улс оронтой харьцуулахад бүтэн цагийн номлолд үйлчилсэн гишүүдийн тоо харьцангуй

өндөр хувьтай гэдгээрээ онцлог юм. 2001 онд Шанхай хотод зохион байгуулсан уулзалт дээрх Сүмийн Ерөнхий удирдлагын илтгэлд Азийн бүсээс илгээгдсэн номлогчдын 40%-ийг монголчууд бүрдүүлж байсныг онцолжээ. Мөн Монгол нь 1990-ээд оны сүүлээр бүс нутагтаа нэг номлогчид ногдох баптисмын тоогоор хамгийн өндөр үзүүлэлттэй байв (Martinich, 2013).

1995 онд Монголд ердөө 16 залуу номлогч үйлчилж байсан бол 1997 онд энэ тоо 34 болж өссөн; 1999 он гэхэд дор хаяж 70 номлогчтой болж, 1999 оны сүүлчээр 100-ын босгыг давжээ (Cook, 1999). 2009 оны дунд үе гэхэд 155 монгол номлогч дотоод, гадаадад үйлчилж байсан бөгөөд 115 нь Улаанбаатар Номлолд үйлчилж байлаа (Phillips, 2009). 2009 оны эцэст энэ тоо 226 болж, өмнөх хоёр жил хагасын хугацаанд ердөө 40 монгол залуу номлогч байсан байдалтай харьцуулахад маш огцом өсөлт байв (Martinich M. , 2013).

Боловсролын хувьд ЕХХҮГС-ийн гишүүдийн дийлэнх нь дээд боловсрол эзэмшсэн эсвэл их, дээд сургуулийн оюутнууд байдаг. Энэ нь сүмийн номлолын нэгэн чухал онцлог болох англи хэлний сургалт, боловсролын төсөлтэй холбоотой ажээ. Өөрөөр хэлбэл, боловсролын хүрээнд сүмтэй холбогдсон залуусын хувьд шашны үзэл санаа нь сурч хөгжих хэрэгцээтэй нь уялдсан гэж судлаачид тэмдэглэжээ (Searle, 2007).

ЕХХҮГС-ийн гишүүдийн шашны зан үйл, практик дэлхийн бүх улс орнуудад нэгэн ижил бүтэц, зохион байгуулалттай байдаг. Ням гариг бүрийн ариун ёслолын цуглаан нь шашны амьдралын гол төв бөгөөд гэр бүлээрээ оролцох уламжлал нэгэнт тогтсон байна. Сүсэгтнүүд гэрийн мөргөл буюу хувийн хөгжилд онцгой ач холбогдол өгдөг бөгөөд “гишүүн бүр номлогч” гэсэн зарчим Монголд идэвхтэй хэрэгждэг

ажээ. Гэр бүлийн оройн мөргөл (family home evening) болон залуу үеийн семинар, институтын хөтөлбөрүүд монгол сүсэгтнүүдийн чөлөөт цагийн соёлын нэг хэсэг болж, тэдний зан үйлд дадал болон суусан байна.

Монгол Улс дахь ЕХХҮГС-ийн сүсэгтнүүдийн зан суртахуун, соёлын онцлогийг судалж үзвэл, тэдний итгэл бишрэлийн практик нь зөвхөн “барууны загвар” эсвэл сүмийн жишгээр хязгаарлагдаагүй байх бөгөөд монголчуудын уламжлалт соёл, зан заншил, шашны өвтэй харилцан нөлөөлж, синкретик шинжийг олж байгаа нь харагдаж байна. Жишээлбээс сүсэгтнүүдийн дунд өвөг дээдсийнхээ шашин шүтлэгтэй холбоотой бэлгэдэл, эд өлгийн зүйлсийг хадгалах явдал түгээмэл ажиглагддаг. Шууд утгаараа мөргөх, сүсэглэх үйлдлийг хийдэггүй боловч, гэр бүлийн түүх, өв уламжлалыг хадгалан үлдэхийн тулд өвөг дээдсийнхээ бурхан тахил, гэрийн шүтээн зэрэг биет өвийг үр хүүхдэдээ өвлүүлэхийг хичээдэг ажээ. Энэ нь нэг талаас ЕХХҮГС-ийн “өвөг дээдсийн түүхийг хүндэтгэх” гэсэн сургаалтай ч холбоотой бололтой.

Мөн сүмийн тэмдэглэлт үйл явдлууд, тухайлбал баптисм, гэрлэлтийн ёслол, шинэ гишүүдийг угтан авах арга хэмжээнд монгол ахуй, үндэсний өнгө аяс тусгахыг хичээх нь бий. Монгол дээл хувцас өмсөх, үндэсний хоолоор зочлох, гэр бүл төвтэй уламжлалт зан үйлсийг сүмийн баяртай уялдуулан тэмдэглэх зэрэг нь гишүүдийн хувьд шинэ итгэлээ “монголжуулах” нэг хэлбэр болж байгаа ажээ. Энэ нь ч уг шашинд итгэх нэг чухал түлхэц болсон гэж ярилцлагын судалгаанд оролцсон сүсэгтнүүд дурдаж байв.

Энэ үзэгдэл нь хоёр талтай. Нэг талаар, сүсэгтнүүд ЕХХҮГС-ийн албан ёсны сургаал, дэг жаягтай зөрчилдөхгүйгээр өөрийн уламжлалт соёлын хэв шинжийг хадгалж үлдэхийг

чармайж буй нь уг шашин Монголын нийгэмд нутагших үйл явц шилжилтийн шатандаа байгааг илтгэнэ. Нөгөө талаар, монголчуудын ЕХХҮГС-ийг хүлээн авч буй байдал нь “гаднын шашныг шууд даган дуурайх” төдий бус, харин “өөрийн ахуй соёлд тохируулан шингээж, өөриймшүүлэх” стратеги давамгайлж буйг харуулж байна. Ийм үзэгдэл нь шинэ шашны хөдөлгөөнүүдийн төлөвшлийн нийтлэг хэв шинжүүдийн нэг болохыг өмнөх судалгаанууд харуулдаг.

ЕХХҮГС-ийн сүсэгтнүүдийн амьдралын хэв маягийн нэг чухал төв нь гэр бүл байдаг. Монгол сүсэгтнүүдтэй хийсэн ярилцлагаас үзвэл гэр бүлтэйгээ “лацлагдах”, өөрөөр хэлбэл “дараа төрөлдөө Бурханы хаант улсад гэр бүлийн хамт дахин төрөх тухай” номлол нь энэ шашинд итгэх нэг шалтгаан болсон гэж хариулсан тохиолдол багагүй байна. Гэр бүлийн нэгдмэл байдал, хүүхдийг зөв хүмүүжүүлэх, ёс суртахууныг сахих зэргээр гэр бүлээ аварч үлдэх явдал нь сүсэгтнүүдэд маш чухал ажээ.

Нөгөөтэйгүүр, архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээ, гэр бүлийн үнэнч бус байдал зэрэг таагүй үзэгдлээс үүдэн ахуй амьдралын бэрхшээлтэй тулгарч байсан хүмүүст хорт зуршлаас татгалзах, цэвэр ариун байдлыг сахих, гэр бүлдээ үнэнч байх зэрэг зарчмуудыг санал болгосон нь шашинд орох нэг чухал шалтгаан болжээ.

Нийгэм, хүмүүнлэгийн үйл ажиллагаа

ЕХХҮГС-ийн үйл ажиллагааны нэг чухал чиглэл бол нийгмийн үйлчилгээ буюу хүмүүнлэг, боловсрол, эрүүл мэндийн төслүүд юм.

ЕХХҮГС Монгол Улсад үйл ажиллагаагаа эхлүүлсэн цагаасаа боловсрол, хүмүүнлэгийн төсөлд онцгой ач холбогдол өгч иржээ. Ерөөсөө анхны ахмад номлогчид 1992 онд Улаанбаатар

ирэхдээ л шашны бус үйл ажиллагаа буюу англи хэлний сургалт, дээд боловсролын хөтөлбөрт туслах үүрэгтэй оролцож байв. Үүнээс улбаалан сүмийн боловсролын хөтөлбөр Монголын их, дээд сургуулийн орчинд эрчимтэй нэвтэрч, олон зуун оюутан англи хэлний сургалтад хамрагдсан нь сүмийг таниулан, сүсэгтний эхний үеийг бүрдүүлэхэд чухал нөлөө үзүүлжээ (Searle, 2007).

ЕХХҮГС-ийн хөгжлийн стратегийн нэг чухал тулгуур нь боловсрол ажээ. Энэхүү чиглэлийг хөгжүүлэхэд “Монгол Улаанбаатар” номлолын анхны ерөнхийлөгчөөр ажилласан Ричард Күүк болон Мари Күүк нар чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Тэдний санаачилгаар Монголын боловсролыг дэмжих сан (Mongolian Education Endowment Fund)-г үүсгэн байгуулсан бөгөөд энэ нь Монголын залуусыг Хавай дахь Брингхам Янгийн их сургуульд (Brigham Young University–Hawaii (BYU–Hawaii))-д суралцах боломжийг олгох зорилготой байв (Brigham Young University–Hawaii, 2020). Уг сан нь сүмийн гишүүдийн хандив болон Хавай дахь Брингхам Янгийн их сургуулийн хамтын ажиллагаанд тулгуурласан бөгөөд 1998 оноос хойш 500 гаруй монгол залууст сургалтын төлбөр болон амьжиргааны зардлын тэтгэлэг үзүүлжээ.

Тус сангийн дэмжлэгтэйгээр Монгол Улс дахь ЕХХҮГС-ийн удирдах ажилтнууд ч Хавай дахь Брингхам Янгийн их сургууль болон бусад сүмийн боловсролын байгууллагад суралцаж бэлтгэгджээ. Монголын боловсролын хөгжилд оруулсан хувь нэмрийг нь өндрөөр үнэлж, Ричард Күүкийг Монгол Улсын Засгийн газар 2023 онд Алтан гадас одонгоор шагнажээ (El-Cheikh, 2023).

ЕХХҮГС-ийн Монгол дахь боловсролын хөтөлбөр нь зөөлөн хүчний бодлогын нэг бодит жишээ гэж хэлж

болно. Нэг талаас боловсролоор дамжуулан монголын олон зуун залуус өндөр боловсрол, мэдлэг чадвар эзэмшсэний зэрэгцээ нөгөө талаар, сүмийн гишүүдийн мэргэжлийн болон удирдах чадвар дээшилсэн, сүмийн ирээдүйн удирдагчид бэлтгэгдсэн, Монгол Улс дахь сүмийн нийгмийн нэр хүнд нэмэгдэж, төрийн байгууллагуудтай хамтын ажиллагааны шинэ шат эхэлсэн зэргийг дурдаж болно.

Зөвхөн боловсролын төдийгүй эрүүл мэндийн (хөдөлгөөний бэрхшээлтэй иргэд зориулсан тэргэнцэр, эмнэлгийн тоног төхөөрөмж, мэргэжилтэн), гамшигийн үеийн (ган, зуд, үер), амьжиргааны түвшингээс доогуур орлоготой иргэдэд зориулсан тусламж дэмжлэг зэргээр хүмүүнлэгийн ажлыг эрчимтэй явуулж ирсэн байна.

Сүмийн бишопын дэлгүүр болон халамжийн төвүүд ядуу, эмзэг бүлгийн өрхүүдэд хүнсний болон өрхийн хэрэглээний тусламж үзүүлдэг тогтолцоо сүмийн нэг чухал хэсэг болон ажилладаг. Монгол дахь сүм ч олон улсын хүмүүнлэгийн сүлжээний нэг хэсэг болж, тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлж иржээ. Сүмийн Залуу эмэгтэйчүүдийн бүлэг хэрэгцээтэй иргэдэд туслах зорилгоор хөнжил оёх, хүнс болон ахуйн багц бэлдэх, хог хаягдал цэвэрлэх, байгаль орчин хамгаалах зэрэг сайн дурын ажил зохион байгуулж ажилладаг байна.

ЕХХҮГС-ийн хүмүүнлэгийн үйл ажиллагааг гардан зохион байгуулагч нь LDS Charities байгууллага бөгөөд Монгол Улсад Дээрэт олон улсын энэрлийн байгууллага (ДОУЭБ) нэртэйгээр танигджээ. Энэ байгууллага нь “хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд чиглэсэн хүмүүнлэгийн үйл ажиллагаагаар дамжуулан хүмүүсийн ачааг хөнгөвчлөх мөн бие даахад нь туслах” зорилготой ашгийн бус, сайн дурын байгууллага ажээ. ЕХХҮГС-ээс санхүүждэг бөгөөд

энэхүү төслийн санхүүжилт нь дэлхийн олон улс оронд буй сүмийн гишүүдийн хандиваар бүрддэг.

ДОУЭБ нь Монгол Улсад хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдэд тэргэнцэр хандивлах, нярайн эрүүл мэндийг дэмжих сургалт, тоног төхөөрөмж хандивлах, орлого багатай иргэдийн харааны эрүүл мэндийн үйлчилгээг чанаржуулах, хүн амыг тогтвортой цэвэр усны эх үүсвэрээр хангах, хүнсний аюулгүй байдал, үйлдвэрлэлийг дэмжих зэрэг чиглэлээр хүмүүнлэгийн туслалцаа үзүүлдэг байна.

2005 оны ДОУЭБ-ын тайланд 1997 оноос хойш монголын төрийн болон төрийн бус байгууллагууд ДОУЭБ-ээр дамжуулан тэргэнцэр, өвлийн хувцас хунар, гутал, ариутгалын багц, эрүүл мэндийн болон шүдний эмчилгээний багаж хэрэгсэл, нярайн багц хэрэгсэлүүд, хуурай сүү, ном, хичээлийн хэрэгсэл зэрэг барааг багтаасан олон арван чингэлэгийн тусламжийн барааг илгээсэн гэж тайлагнажээ (Po Nien (Felipe) Chou, Petra Chou, 2022).

ЕХХҮГС-ийн хүмүүнлэгийн үйл ажиллагаа Монгол Улсад гурван үндсэн үе шаттайгаар өрнөсөн гэж үзэж болно.

1. Анхны үе (1990-ээд оноос 2000 он хүртэл): Онцгой байдлын нөхцөлд хүнс, хувцас, бусад хэрэгцээт зүйлсийг хандивлан хүргэхэд төвлөрч байв.
2. Хөгжлийн үе (2000-аад он): Эрүүл мэнд, боловсрол, амьжиргааны ур чадвар олгох чиглэлээр сургалт, төсөл хэрэгжүүлсэн.
3. Нутагшсан үе (2010 оноос хойш): Гадаадын тусламжаас дотоодын гишүүдийн санаачилгатай хамтын ажиллагаа руу шилжиж, орон нутгийн хэрэгцээнд нийцсэн төслүүд давамгайлж байна.

Энэ үйл явц нь Монгол дахь ЕХХҮГС-ийн хүмүүнлэгийн ажил

зөвхөн гадны тусламжийн шинжтэй байгаагүй, харин цаг хугацааны явцад дотоодын сүсэгтэн, иргэдийн оролцоо, орон нутгийн чадавхийг нэмэгдүүлэх чиглэлд хөгжсөнийг харуулж байна.

ЕХХҮГС-ийн хүмүүнлэгийн төсөл нь нэг талаас Монголын нийгэмд эерэгээр хүлээн зөвшөөрөгдөхөд чухал үүрэгтэй. Хүмүүнлэгийн төсөл, боловсролын дэмжлэгийн үр дүнд “нийгэмд хувь нэмэр оруулагч” гэсэн дүр төрхтэй болсон (Knowlton, 2005).

Сүүлийн жилүүдэд ЕХХҮГС шашин хоорондын харилцаа, хамтын ажиллагааг чухалчилан үзэх болжээ. Энэ хүрээнд сүмийн удирдлагын зүгээс Бурханы шашин (Дашчойлин Зүүнхүрээ хийд), Христийн шашин (Католик сүм, Үнэн алдартны шашны Тройцкийн сүм), Монголын мусульманы нийгэмлэг, Монголын бөөгийн нэгдсэн эвлэл, Шинто шашны Оомото байгууллага, Монголын Бахайн нийгэмлэг зэрэг Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллагуудын төлөөллүүдтэй тогтмол уулзалт, харилцан бие биенээ таньж мэдэх, мэдлэг солилцох арга хэмжээ, хамтын хүмүүнлэгийн болон сайн үйлсийн аян зохион байгуулах зэрэг ажлыг идэвхитэй зохион байгуулах болсон байна.

IV. ДҮГНЭЛТ

Монгол дахь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм (ЕХХҮГС) нь 1990-ээд оноос эхлэн богино хугацаанд хүчтэй тэлж, өнөөдрийн Монголын шашны ландшафтын онцлог бүрэлдэхүүн хэсэг болон төлөвшжээ. Түүхийн хувьд, сүмийн эхэн үеийн өсөлтөд номлолын үйл ажиллагаа, англи хэлний сургалт, боловсролын дэмжлэг, мөн хүмүүнлэгийн төсөл зэрэг “зөөлөн хүчний” хэлбэрүүд онцгой нөлөө үзүүлсэн байна. Үүний зэрэгцээ шашны гол эх сурвалжуудыг монгол хэлнээ орчуулан хэрэглэсэн нь гишүүдийн

шашны мэдлэг, дадлыг бэхжүүлж, дотооддоо өөрсдөө номлогчоор үйлчлэх чадвар суулгажээ.

Өнөөдрийн байдлаар ЕХХҮГС нь Монголд институцийн хувьд олон улсад нийтлэг хөгжсөн загварын дагуу төлөвшиж, бэхэжсэн байна. Зохион байгуулалтын хувьд 2024–2025 оны байдлаар хоёр гадас, нэг дүүрэг, 12 тойрог, 12 салбар нэгж, нэг номлол (mission), 10 гэр бүлийн түүхийн төв ажиллаж байгаа нь энэ шашны хөдөлгөөн тоо хэмжээний хувьд төдийгүй, бүтцийн хувьд ч нарийн зохион байгуулалттай болж тогтсоныг харуулж байна.

Монгол дахь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм (ЕХХҮГС)-ийн сүсэгтнүүдийн хүн ам зүйн бүтэц, шашны зан үйл, соёлын онцлог нь олон улсын нийтлэг хэв шинжийг хадгалсан хэрнээ монголчуудын уламжлалт ахуй, үнэт зүйлстэй нягт уялдсан хосолмол шинжийг илэрхийлж байна. Анхны үеийн сүсэгтнүүдийг оюутан, залуу гэр бүлүүд, 18–35 насны залуус бүрдүүлж байсан нь сүмийн хурдацтай өсөлтөд шууд нөлөөлсөн бөгөөд энэ төлөв байдал өнөөдөр ч сүсэгтнүүдийн бүтцэд тодорхой хэмжээгээр ажиглагдсаар байна. Мөн эмэгтэйчүүд давамгайл байдалтай оролцож байгаа нь Монгол дахь шашин шүтлэгийн нийтлэг хүн ам зүйн дүр зурагтай уялдаж байна.

Ням гаригийн ариун ёслолын цуглаан, гэр бүлийн оройн мөргөл, залуучуудын семинар зэрэг тогтсон шашны үйл ажиллагаа, зан үйл нь сүсэгтнүүдийн амьдралын чухал хэсэг болон төлөвшжээ. Үүний зэрэгцээ монголчуудын өвөг дээдсийн уламжлалт шүтлэгийн бэлгэдлийг хадгалах, сүмийн тэмдэглэлт үйл явдлыг үндэсний өнгө аяс, ахуйтай уялдуулах зэрэг соёлын элементүүд ЕХХҮГС-ийн сүсэгтнүүдийн дунд ажиглагддаг нь уг

шашныг “гаднаас нэвтэрсэн” гэхээс илүү “нутагшсан” үзэгдэл болгож байна.

Нийгэмд үзүүлж буй нөлөөллийн хувьд, ЕХХҮГС-ийн хүмүүнлэгийн үйл ажиллагаа (эмнэлэг, боловсрол, өрхийн амьжиргааг дэмжих, байгаль орчны асуудал, хүнсний аюулгүй байдал гэх мэт) нь сүмийг “нийгэмд хувь нэмэр оруулагч” хэмээх эерэг дүр төрхтэй болгожээ. Үүнээс гадна боловсрол, ялангуяа англи хэлний сургалт болон боловсролын боломжууд сүсэгтнүүдийн дунд өргөн тархсан нь ЕХХҮГС-ийн шашны үйл ажиллагааг залуу үеийнхний сонирхол, хөгжлийн хэрэгцээтэй уялдуулан нутагшуулахад дэмжлэг болсон байна.

Төрийн болон төрийн бус байгууллагууд төдийгүй, шашин хоорондын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх тал дээр сүм идэвхтэй ажиллаж, Бурханы шашин, Христийн бусад урсгал, Ислам, Бөө мөргөл, Шинто, Бахай зэрэг шашны байгууллагуудтай уулзалт, сайн үйлсийн аян зохион байгуулах зэргээр олон талт хамтын ажиллагааг хөгжүүлж буй нь шашны эв нэгдэл, харилцан ойлголцлыг бэхжүүлэх бодит хувь нэмэр болж байна.

Ийнхүү Монгол дахь ЕХХҮГС нь богино хугацаанд төлөвшин тогтож, идэвхтэй гишүүнчлэл, нийгмийн хүмүүнлэгийн оролцоо, институцийн бэхжилтийн хувьд өвөрмөц загварыг бий болгож, Монголын шашны ландшафтад

өөрийн гэсэн орон зай, байр сууриа олж авчээ. Цаашид бидэнд:

1. Монгол дахь ЕХХҮГС-ийн гишүүдийн хүн ам зүйн өөрчлөлт, ялангуяа үеийн ялгаа болон сүсэгтнүүдийн шилжилт, шашнаа солих, хөрвөх үзэгдлийн нөлөө;
2. Сүсэгтнүүдийн идэвх, шашны оролцооны динамик өөрчлөлт болон бууралт, өсөлтийн шалтгаан;
3. Сүмийн хүмүүнлэгийн болон боловсролын төслүүдийн Монголын нийгэмд үзүүлсэн бодит үр нөлөө;
4. Уламжлалт монгол соёл, зан заншил, шашны өв ба ЕХХҮГС-ийн практик хоорондын уялдаа, синкретик шинжид хийх шинжилгээ;
5. Шашин хоорондын харилцаанд ЕХХҮГС-ийн оролцоо, түүний нийгэм-соёлын цаашдын нөлөөллийн чиг хандлага зэргийг гүнзгийрүүлэн судлах хэрэгцээ үүсч байна.

Монгол Улс дахь ЕХХҮГС-ийн түүхэн хөгжлийн онцлог, соёлын нутагшил, нийгэм-соёлын нөлөөллийн талаарх судалгааг цаашид өргөжүүлэн хийх нь зөвхөн шашин судлал төдийгүй түүх, социологи, антропологи, соёл судлал зэрэг нийгэм, хүмүүнлэгийн ухааны бусад салбаруудын хувьд ч чухал ач холбогдолтой юм.

Ашигласан материал

Ж.Алтайбаатар. (2012). Монгол дахь шашин шүтлэгийн өнөөгийн байдал. *Философи, эрх зүйн судлал*, XXVII.

С.Цэдэндамба, С.Янжинсүрэн, Ж.Алтайбаатар, Б.Мөнхцацралт, С.Дэмбэрэл, О.Бумдарь. (2020). *Монгол улс дахь шинэ шашнууд: Нийгмийн төрх, асуудал, шийдэл*. Улаанбаатар: ШУА, ФХ. *Сургаал ба Гэрээ*. (n.d.).

ҮСХ. (2020). *Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн*. Улаанбаатар: ҮСХ.

2024 Statistical Report of The Church of Jesus Christ of Latter-day Saints. (2025, 4 5). Retrieved from The Church of Jesus Christ of Latter-Day Saints: <https://newsroom.churchofjesuschrist.org/article/2024-statistical-report>

Andrew F. Ehat, Lyndon W. Cook. (1980). *The Words of Joseph Smith: The Contemporary Accounts of the Nauvoo Discourses of the Prophet Joseph*. Salt Lake City: Bookcraft. *Apostles Visit Church Members in India, Hong Kong and Mongolia*. (2011, 6 2). Retrieved

- from The Church of Jesus Christ of Latter-Day Saints: https://newsroom.churchofjesuschrist.org/article/apostles-visit-india-hong-kong?utm_source=chatgpt.com
- Benson, E. T. (1986, 10). *The Book of Mormon—Keystone of Our Religion*. Retrieved from https://www.churchofjesuschrist.org/study/general-conference/1986/10/the-book-of-mormon-keystone-of-our-religion?lang=eng&utm_source=chatgpt.com
- Beyer, P. (2006). *Religions in Global Society*. Routledge.
- Brigham Young University–Hawaii. (2020, 1). *Leaving a Legacy in Mongolia*. Retrieved from [Philanthropies: philanthropies.churchofjesuschrist.org](http://philanthropies.churchofjesuschrist.org)
- Bushman, R. L. (2005). *Joseph Smith: Rough Stone Rolling*. Knopf.
- C.Gessel, V. (2015). Mormons in Asia. In P. L. Terry L.Givens, *The Oxford Handbook of Mormonism* (pp. 559-576). New York: Oxford University Press. <https://doi.org/10.1093/oxfordhb/9780199778362.013.35>
- Cesari, J. (2013). *Why the West Fears Islam: An Exploration of Muslims in Liberal Democracies (Culture and Religion in International Relations)*. Palgrave Macmillan.
- Cook, M. N. (1999, 7 3). *Well-known building is first meetinghouse in Mongolia*. Retrieved from LDS Church News, 3 July 1999.: <http://www.ldschurchnews.com/articles/35993/Well-known-building-is-first-meetinghouse-in-Mongolia.html>
- Cosgrove, D. E. (1984). *The social formation and symbolic landscape: with a new introduction*. London: The University of Wisconsin Press.
- Durkheim, E. (1976). *The elementary forms of religious life, second edition*. London: George Allen and Unwin. First published in 1915.
- El-Cheikh, H. (2023, 10 17). *Mongolian ambassador visits BYU to present Order of the Polar Star*. Retrieved from The Daily Universe: <https://universe.byu.edu/2023/10/17/mongolian-ambassador-visits-byu-to-present-order-of-the-polar-star-ef-bf-bc/>
- Eliade, M. (1959). *The sacred and the profane: the nature of religion*. San Diego: Harcourt Brace Jovanovich.
- Geertz, C. (1966). *The Interpretation of Cultures*.
- Geertz, C. (1993). Religion as a cultural system. In C. Geertz, *The interpretation of cultures: selected essays* (pp. 87-125).
- Givens, T. L. (2003). *By the Hand of Mormon: The American Scripture that Launched a New World Religion*. <https://doi.org/10.1093/019513818X.001.0001>
- Harper, S. (2013). *Making Sense of the Doctrine & Covenants: A guided tour through modern revelation*. Deseret Book.
- Heaton, T. B. (1998). Religious Influences on Mormon Fertility. In J. T. Duke, *Latter-day Saint Social Life: Social Research on the LDS Church and its Members* (pp. 425-440). Provo, UT: Religious Studies Center, Brigham Young University.
- Isaac, E. (1965). Religious geography and the geography of religion. University of Colorado Studies, Series in Earth Sciences no. 3. . In *Man and the Earth* (p. 10). Boulder, CO: University of Colorado Press.
- Kong, L. (1990). Geography and religion: trends and prospects. *Progress in Human Geography*, 14(3), 355-371. Retrieved from <https://doi.org/10.1177/030913259001400302>
- Kong, L. (2008). Religious Landscapes. In N. C. James S. Duncan, *A Companion to Cultural Geography* (pp. 365-381). Blackwell Publishing. <https://doi.org/10.1002/9780470996515.ch24>
- Martinich, M. (2013, 8 9). *Recent Stagnant LDS Growth in Mongolia*. Retrieved from International Resources for Latter-day Saints: <https://www.cumorah.com/articles/ldsGrowthCaseStudies/594>
- Martinich, M. (2013, 8 9). *Recent Stagnant LDS Growth in Mongolia*. Retrieved from www.cumorah.com: https://www.cumorah.com/index.php?target=view_other_articles&story_id=594&cat_id=
- Mongolia Dedicated for preaching of the Gospel*. (1993, 6 19). Retrieved from Deseret News:

- <https://www.deseret.com/1993/6/19/20765765/mongolia-dedicated-for-preaching-of-the-gospel/>
- Oaks, D. H. (2001). The Historicity of the Book of Mormon. In P. Y. Hoskisson, *Historicity and the Latter-day Saint Scriptures* (pp. 237–248). Provo, UT: Religious Studies Center, Brigham Young University.
- Otto, R. (1950). *The idea of the holy, second edition*. London: Oxford University Press. First published in 1917.
- Peter L. Berger, Thomas Luckmann. (1967). *The Social Construction of Reality: A Treatise in the Sociology of Knowledge*. Anchor.
- Phillips, J. (2009, 6 10). *First stake in Mongolia is organized*. Retrieved from LDS Church News: <http://www.ldschurchnews.com/articles/57449/First-stake-in-Mongolia-is-organized.html>
- Po Nien (Felipe) Chou, Petra Chou. (2022). *Voice of the saints in Mongolia*. Salt Lake City: BYU.
- PRRI. (2012, 5 1). The 2012 Religious Congregations and Membership Survey (RCMS).
- Searle, D. L. (2007, 12). *Mongolia: Steppes of Faith*. Retrieved from Church Magazines: <https://www.churchofjesuschrist.org/study/ensign/2007/12/mongolia-steppes-of-faith?lang=eng>
- Semerad, T. (2025, 4 1). *Why the LDS Church soon may not need tithing anymore to cover its global programs*. Retrieved from The Salt Lake Tribune: <https://www.sltrib.com/religion/2025/04/01/lds-church-wealth-day-soon-may/>
- Shippo, J. (1987). *Mormonism: The Story of a New Religious Tradition*.
- Smith, J. (1830). *Book of Mormon*. New York: E. B. Grandin: Palmyra.
- Stapley, J. (2018). *The Power of Godliness: Mormon Liturgy and Cosmology*. Oxford University Press. <https://doi.org/10.1093/oso/9780190844431.001.0001>
- The Church in Mongolia*. (2025). Retrieved from The Church of Jesus Christ of Latter-Day Saints: <https://www.churchofjesuschrist.org/learn/facts-statistics/mongolia?lang=eng>
- Vasquez, M. A. (2011). *More Than Belief: A Materialist Theory of Religion*. Oxford University Press.
- Weber, M. (1904-1905). *The protestant ethic and the spirit of capitalism*.